



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 8/532

Арвайхээр

Газар ашиглалтын зориулалтад өөрчлөлт оруулах тухай


Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын даргын 2008 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 83 дугаар тушаалаар батлагдсан "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3.4.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр сумын 5 дугаар баг Б.Ренчинпэлжээгийн нэрэмжит 1 дүгээр гудамж 141 тоотод байрлах иргэн Б.Идэр (ЦД86080574)-ийн эзэмшил худалдаа, нийтийн үйлчилгээний зориулалттай 2099м² газрын зориулалтыг 9 ба түүнээс дээш давхар нийтийн орон сууцны, Мэргэд 5 дугаар гудамж 501 тоотод байрлах иргэн О.Сэмжаан (ЙЮ94041512)-ы эзэмшил гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 727м² газрын зориулалтыг 5-8 давхар нийтийн орон сууцны зориулалттай болгон тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Дээрх газар эзэмших эрхэд гарсан өөрчлөлтийг газрын улсын бүртгэлд бүртгэж, гэрээг зохих журмын дагуу байгуулан, гэрчилгээ олгохыг аймгийн Засаг даргын дэргэдэх Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011100711